

МОНГОЛ УЛС ДАХЬ ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДАЛ: ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

Н. Ариунтуяа

*Сэтгэл судлалын ухааны доктор (Ph. D.), дэд профессор
Шинжлэх ухаан, технологийн их сургууль. Бизнесийн удирдлага,
хүмүүнлэгийн сургууль*

ariuntuuya.n@must.edu.mn

Хураангуй: Энэхүү өгүүлэлд Монгол улс дахь жендэрийн эрх тэгш байдал, тулгамдсан асуудлуудыг баримтын анализын аргаар судлан тодорхойлсон. Жендэрийн эрх тэгш байдлыг жендэрт суурилсан хүчирхийлэл, хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, хүн амын хөгжил, боловсрол, эрүүл мэндийн салбар дахь жендэрийн асуудал, улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо гэсэн чиглэлээр авч үзлээ.

Түлхүүр үгс: Жендэрт суурилсан хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэрэг, ажлын байран дахь бэлгийн дарамт, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо/төлөөлөл

УДИРТГАЛ ХЭСЭГ

Тогтвортой хөгжлийн 5 дахь зорилго нь жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл явцыг эрчимжүүлэх хэмээн заасан. Энэхүү зорилгыг хэрэгжүүлэхийн тулд өнөөгийн нөхцөл байдлыг судлан тодорхойлох шаардлагатай билээ. Монгол улсын хэмжээнд сүүлийн жилүүдэд хийгдсэн жендэрийн талаар хийгдсэн судалгааны ажлуудыг тоймлож үзсэнээрээ онцлогтой.

ОНОЛ, АРГА ЗҮЙН ХЭСЭГ

2017 оны байдлаар Монгол улс жендэрийн тэгш бус байдлын индексээр 0.301 буюу дэлхийн 189 орноос 65-р байранд оржээ [1]. Түүнчлэн эмэгтэйчүүдийн эдийн засгийн оролцоо, боловсролын түвшин, эрүүл мэнд, бодлогын түвшин дэх эрх мэдэл гэсэн үзүүлэлтээр дэлхийн эдийн засгийн форумас тооцож гаргасан 2017 оны жендэрийн тэгш байдлын индексээр Монгол улс дэлхийд 53-рт бичигдэж, бодлогын түвшин дэх эмэгтэйчүүдийн эрх мэдлийн үзүүлэлтээр нэлээд доогуур 107-д орсон байна [2].

Монгол улс жендэрийн эрх тэгш байдлыг хангах, дэмжих зорилготой хууль, бодлогын үндсэн баримт бичгүүдийг батлан хэрэгжүүлж байгаа бөгөөд Зүүн Ази, Номхон Далайн бүс нутгийн ихэнх улс орнуудтай

харьцуулахад манай улсыг жендэрийн тэгш байдлыг хангахад томоохон ахиц дэвшил гаргасан хэмээн олон улсын байгууллагууд дүгнэдэг.

НҮБ-ын Хүний эрхийн төлөв байдлын ээлжит хэлэлцүүлгийн (UPR) тайлан, эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай НҮБ-ын конвенцийн (CEDAW) тайлан, нийгэм, соёлын эрхийн талаарх НҮБ-ын тайланд Монгол улс жендэрийн тэгш байдлыг хангах талаар дараах хоёр үзүүлэлтээр дэлхийгээс хоцорч явааг онцолжээ.

Нэгдүгээрт, төр, хувийн хэвшилд шийдвэр гаргах түвшинд алба хашиж буй эмэгтэйчүүдийн тоо.

Хоёрдугаарт, Жендэрт суурилсан хүчирхийллийн асуудал юм.

Үүнээс гадна жендэрийн тэгш бус байдал хэд хэдэн чиглэлээр оршсоор байгааг дараах судалгаануудаас харж болох юм. Энэхүү өгүүлэл нь монгол улс дахь жендэрийн тэгш бус байдлын тулгамдсан асуудлыг тоймлон авч үзсэнээрээ шинэлэг юм.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

2012-2018 оны хооронд монгол улсад хийгдсэн жендэрийн талаарх тоон болон чанарын судалгааны ажлуудад баримтын анализ хийсэн.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ


1. Жендэрт суурилсан хүчирхийлэл

Монголд жендэрт суурилсан хүчирхийллийн дараах хэлбэрүүд илүү түгээмэл байна. Үүнд: гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэрэг, ажлын байран дахь бэлгийн дарамт болно [3].

2017 онд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалыг ашиглан, улс орон даяар анх удаа зохион байгуулсан Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгааг Үндэсний статистикийн хороо хийж гүйцэтгэсэн байна. Судалгаанд 21 аймаг 9 дүүргийн 7319 эмэгтэй хамрагджээ. Энэхүү судалгаагаар хамтрагчтай байсан/байгаа нийт эмэгтэйчүүдийн 29.7 хувь нь амьдралдаа хамтрагчийн үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн бол 11.9 хувь нь сүүлийн 12 сард хамтрагчийн үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн байна. Хамтрагчийн үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь үүнээс бага буюу эмэгтэйчүүдийн 8.0 хувь нь амьдралдаа хамтрагчийн үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд өртсөн бол 3.0 хувь нь сүүлийн 12 сард өртжээ. Эмэгтэйчүүд хүчирхийллийн аль нэг хэлбэрт эсвэл хүчирхийллийн олон хэлбэрт давхар өртдөг байна. Тухайлбал, бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн ихэнх нь бие

махбодын хүчирхийлэлд давхар өртдөг. Хүчирхийллийн хэлбэрүүд дотроос хянах зан үйл хамгийн түгээмэл бөгөөд хамтрагчтай байсан/байгаа эмэгтэйчүүдийн 41.6 хувь нь амьдралдаа энэ хэлбэрийн хүчирхийлэлд өртсөн бол сүүлийн 12 сард бараг дөрөвний нэг (23.8 хувь) нь өртсөн байна [4].

Зураг 1. Хамтрагчийн хүчирхийллийн хэлбэрүүд



Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

Энэхүү судалгаагаар бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн 44,9 хувь нь амьдралдаа, 15,5 хувь нь сүүлийн 12 сард бэртэл гэмтэл авч байжээ. Жендэрийн хэвшмэл ойлголт 7 эмэгтэй тутмын 1-д илэрч байгаа бөгөөд бие махбодын болон /эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн 55,4 хувь нь “Сайн эхнэр нөхөртэйгээ санал нийлээгүй ч үгийг нь дагадаг” байр суурийг баримталдаг ажээ.

2017 оны цагдаагийн статистик мэдээллээс авч үзвэл гэр бүлийн хүчирхийллийн улмаас 1040 эмэгтэй хохирсон гэж бүртгэгджээ [5].

Хүн худалдаалах гэмт хэрэг

Хүйсийн тэгш эрхийн төв ТББ өмнөх жилд бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүний наймааны хохирогч болсон байж болзошгүй 36 хүнд тусалцаа үзүүлсэн бол 2016 онд бэлгийн (43 хүн) болон хөдөлмөрийн мөлжлөгийн (1 хүн) хохирогч нийт 44 хүнд тусалжээ. Илрүүлсэн бүх хохирогчид эмэгтэй хүн байсан бөгөөд тэдний нэг нь хүүхэд байв.

Монгол улс нь эрэгтэй, эмэгтэй хүмүүс болон хүүхдийг албадан хөдөлмөр эрхлүүлэх, бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах сурвалж болон хүлээн авагч улс болж байна [6].

Дотооддоо охид, эмэгтэйчүүд массажны газар, зочид буудал, баар цэнгээний газар болон караоке клубүүдэд бэлгийн мөлжлөгийн зорилго бүхий хүний наймаанд өртөж байна. Хүний наймаачид зарим үед хар тамхи, олон нийтийн хуурамч сүлжээ, ажлын байрны цахим зар, англи хэлний хөтөлбөрүүд зэргийг ашиглан хохирогчдыг хууран мэхлэх замаар

бэлгийн мөлжлөгт татан оруулдаг ажээ. Хөдөө орон нутгийн ба эдийн засгийн хувьд ядуу хорооллын хохирогч нар Улаанбаатар хотод болон хилийн ойр орчим бэлгийн мөлжлөгт олноороо өртөж байна хэмээн тус тайланд дурьджээ.

Ажлын байран дахь бэлгийн дарамт

Бэлгийн дарамт гэдэг хүний аюулгүй байдалд заналхийлсэн үйлдэл бөгөөд ажлын байранд тэгш бус байдал үүсэх нөхцөл, шалтгаан болдог [7]. Энэ асуудлыг нийгэм, хүн ард төдийлөн ойлгож, хүлээж авахгүй, бэлгийн дарамт бол хувь хүмүүс хоорондын асуудал гэж үздэг ч үнэн хэрэгтээ энэ бол нийгмийг бүхэлд нь хамарсан асуудал юм. Энэ асуудлыг шийдвэрлэхэд тулгардаг хамгийн том бэрхшээл болох бэлгийн дарамт хэмээх үйлдлийн талаарх ард нийтийн ойлголт маш сул байгаа явдал юм.

2010 онд Монголын эмэгтэйчүүдийн сангаас хийсэн судалгаагаар нийт оролцогчдийн 86.3 хувь нь ажлын байран дээр бэлгийн дарамт байдаг гэдгийг анзаарсан гэж хариулжээ. Ажил гүйцэтгэх явцад ялангуяа өндөр, дээд албан тушаалтны зүгээс бэлгийн дарамт үзүүлэх тохиолдол байдаг гэдгийг мэддэг боловч энэ асуудал зөвхөн найз нөхөд, гэр бүл, хамаатан садны хүрээнд яригдаад өнгөрдөг, олны анхаарлыг татдаггүй байна [8]. Энэ асуудлыг 2017 онд Эрүүгийн хуулинд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр бэлгийн дарамт учруулах (12.4) гэсэн зүйлийг хүчингүй болгожээ.

2. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаан дахь жендэрийн асуудал

Эдийн засгийн боломжийн хүртээмж, цалин хөлс, бүтээмжийн ялгаатай байдал байгааг зарим судалгаануудаар баримтжуулсан байдаг. Хөдөлмөрийн зах зээл дэх жендэрийн тэгш байдал нь нийгэмд хэрхэн сайнаар нөлөөлж болохыг нотлох наад захын гурван шалтгааныг дурьдвал:

Нэгдүгээрт, хөдөлмөрийн зах зээлд эмэгтэйчүүдийн боломжийг бүрэн ашиглах нь макро эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх магадлалтай.

Хоёрдугаарт ажил эрхлэлт нь эмэгтэйчүүдийг хөгжүүлэх, хүчирхэгжүүлэх шууд арга хэрэгсэл болдог.

Гуравдугаарт эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн зах зээлийн боломжийг өргөжүүлэх нь тэдний эрхийн төлөөх үйл ажиллагаанд ч мөн дам эерэг нөлөө үзүүлдэг. Хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлогын хүрээнд эрэгтэй, эмэгтэй хүмүүс ямар дэмжлэг хүсдэг тухай бодитой мэдээлэл хомс, тухайлбал, хөдөлмөр зуучлалын үйлчилгээ болон хөдөлмөр

эрхлэлтийн дэмжлэгүүд нь жендэрийн тодорхой бэрхшээлийг шийдвэрлэхэд хэр үр дүнтэй байгаа талаар мэдээлэл байхгүй байна [9].

2017 оны эцсийн байдлаар эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин 67,5 хувь, эмэгтэйчүүдийнх 55.2 хувь байгаа ба тэдний ажиллаж буй салбарууд ялгаатай, цалин хөлс нь зөрүүтэй байна. Ажил эрхэлж буй эмэгтэйчүүдийн дундаж цалин ажил эрхэлж буй эрэгтэйчүүдийнхээс үргэлж доогуур байна. 2017 оны байдлаар аж ахуйн нэгжид ажиллагч эрэгтэйчүүд 1029400 төгрөг, эмэгтэйчүүд 860000 төгрөгийн цалин авч аж ахуйн нэгжид ялгаа их байгааг харуулж байна.

Манай улсад эрэгтэйчүүдтэй харьцуулахад эмэгтэйчүүд боловсролын түвшин илүү байгаа ч эмэгтэйчүүд боловсролоо ашиглаж хөдөлмөрийн зах зээлд идэвхтэй оролцох боломжоор харьцангуй дутмаг байна хэмээн Монгол улсын хөдөлмөрийн зах зээл дэх жендэрийн тэгш бус байдлын талаарх чанарын судалгааны тайланд онцолжээ. Суурь шалтгааныг судлахад хүүхэд болон ахмад настнуудыг харах үйлчилгээ дутмаг байдгаас эмэгтэйчүүдийн ихэнх нь хөдөлмөр эрхлэх боломжгүй байна.

Аль ч түвшний боловсролтой эмэгтэйчүүдтэй харьцуулахад эрэгтэйчүүдийн хувьд (хөдөө аж ахуйн салбараас гадуур) хувиараа хөдөлмөр эрхлэх боломж хоёр дахин илүү байна [10].

Хөдөлмөрийн зах зээл дэх жендэрийн тэгш бус байдлын үндсэн шалтгаанууд нь гэрлэлт, гэр орны ажил болон бусдыг асран халамжлах, мэргэжил сонголт, ажил эрхлэлтийн асуудлаарх эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн үүргийн хэвшмэл ойлголт, мөн улс төрийн орчин хангалтгүй, төрийн дэмжлэг хөтөлбөрүүд дутагдалтай байдагтай холбоотой байна.

3. Хүн амын хөгжил дэх жендэр


Өнөөдөр монгол хүний дундаж наслалт бараг 70 хүрч байгаа нь хүн амын бодлогын хүрээнд гарсан амжилт боловч хүйсийн ялгаа ихсэн (эмэгтэйчүүд дунджаар 75.4, эрэгтэйчүүд дунджаар 65.8 насалж байна) 9.6 жил болоод байгаа нь жендэрийн хувьд таагүй үзүүлэлт юм. Үүнд: гэмт хэрэгт өртөж нас барах, ял эдэлж хоригдсоноор нас богиносх, өвчлөл, бэртэл хордлогоор нас барах зэрэг нь нөлөөлж байна.

Зураг 2. Гэмт хэрэгт холбогдож нас барсан хүний тоо



Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

Зураг 3. Шүүхээр ял шийтгүүлсэн хүний тоо



Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

Статистик мэдээллээр монгол улсад ядуурлын түвшин 29.6 хувь болсон. Ядууралд өртөж байгаа хүн амын нөхцөл байдал ялгаатай байна. 2017 оны байдлаар 20,6 мянган эрэгтэй өрх толгойлж байгаа бол 76,9 мянган эмэгтэйчүүд өрх толгойлон амьдарч байгаа нь даруй 3,7 дахин их үзүүлэлт юм. Үүнээс 18 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эх 38,1 мянга байна.

Зураг 4. Өрх толгойлсон хүн



Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

Хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн асуудлыг нийгмийн хамгааллын бодлогоор шийдвэрлэдэг. Монгол улсын хүн амын 3.8 хувь нь буюу 96.3 мянган хөгжлийн бэрхшээлтэй хүн байгаагийн 52.7 мянга нь эрэгтэй, 34.5 мянга нь эмэгтэй байна. Хөгжлийн бэрхшээлтэй


хүний хөдөлмөр эрхлэлт, нийгмийн гишүүн байх эрхийг баталгаажуулах асуудал тулгамдсан асуудлын нэг байсаар байна [3].

4. Боловсрол дахь жендэрийн асуудал

БСШУСЯ-наас 2017 онд сургууль завсардсан 6-14 насны хүүхдийн тоог судалгаагаар илрүүлжээ. Энэ насны 682 хүүхэд сургуульд сурахгүй байгаагийн 463 нь, огт сургуульд ороогүй 514 хүүхдийн 318 нь эрэгтэй хүүхэд байна. ХНХЯ-наас хийсэн судалгаагаар 2017 онд 10435 хүүхдийг морь унаач, малчны ажил хийлгэж байгаа гэсэн тоо гарчээ. 2016 онд ХНХЯ, МХЕГ-ын хамтарсан ажлын хэсгийн шалгалтаар 495 хүүхдийг хууль бусаар хөдөлмөр эрхлүүлж байсны 90 хувь нь 14-17 насны хөвгүүд байжээ. Хөвгүүд сургууль завсардах, ерөнхий боловсрол эзэмшиж чадахгүй байгаагийн гол шалтгаан нь мал маллах, ажил хийлгэх гэсэн эцэг эхийн хүсэлтэй холбоотой байна [11].

2017 оны байдлаар ЕБС төгсөгчдийн 47,3 хувь, МСҮТ төгсөгчдийн 61,0 хувь, их дээд сургууль төгсөгчдийн 38,9 хувь нь эрэгтэйчүүд байгаа нь боловсрол эзэмшиж буй байдал ялгаатай байгааг харуулж байна.

Зураг 5. Их, дээд сургууль, коллежийг төгсөгчид



Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан


Нийгэм дэх эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн боловсролын ялгаа их байгаа нь гэр бүлийн хүчирхийлэл үүсэх, гэрлэлт цуцлалт нэмэгдэх, өрх толгойлсон, ганц бие эмэгтэйчүүдийн тоо буурахгүй байгаагийн шалтгаан юм.

5. Эрүүл мэндийн салбар дахь жендэрийн асуудал

Монгол улсад эрэгтэйчүүдийн дундаж наслалт нь 65.8 бөгөөд эмэгтэйчүүдийн дундаж наслалтаас (75.4) даруй 9.6 жилээр богино гэсэн тооцоо гарчээ. Ийм ялгаа аль ч улс оронд байдаг хэдий ч манай улсын хувьд дэлхийн дундаж түвшнээс 2.5 дахин их төдийгүй дэлхийн 187 орноос

15-49 насны 1000 эрэгтэйд ногдох сүүлийн 40 жилийн нас баралтын байдлаар 450-иас дээш үзүүлэлттэй 19 орны нэг байгаа нь эрчүүдийн эрүүл мэндийг онцгойлон анхаарах шаардлагатайг харуулж байна.

Зураг 6. Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад эмгэгээр нас барсан хүний тоо



Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

Монгол улсад 2017 оны байдлаар өвчнөөр нас барсан иргэдийн 60,7 хувь нь эрэгтэйчүүд байна. Үүнээс гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад эмгэгээр нас барсан эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 4,8 дахин их байна.

6. Улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо, боломж

Олон нийтийн дунд улс төрийн шийдвэр гаргах түвшинд “эрэгтэй, эмэгтэйчүүд адил тэгш оролцох ёстой” гэсэн үзэл бодолтой хүмүүс 74,4 хувь байна. Судалгаанд оролцогчид шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо, төлөөлөл хангалтгүй байгаагийн шалтгааныг эрэгтэйжсэн улс төрийн бүтэцтэй холбон үзэж байна [12]. 2016 оны УИХ-д сонгогдсон нийт гишүүдийн 13 нь буюу 17.1 хувь нь эмэгтэйчүүд байна. Улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо, төлөөлөл доогуур байгаа шалтгаанд нэр дэвшиж буй эмэгтэйчүүдийн тоо цөөн байгаа, нам дахь эмэгтэйчүүдийн нөлөө сул байгаа, улс төрч эмэгтэйчүүдийн талаарх мэдээлэл бага, сонгуулийн луйвар газар авсан гэж хариулсан оролцогчид олон байжээ.

ДҮГНЭЛТ

1. Эмэгтэйчүүд хүчирхийллийн аль нэг хэлбэрт эсвэл хүчирхийллийн олон хэлбэрт давхар өртөж байна.
2. Охид, эмэгтэйчүүд бэлгийн болон хөдөлмөрийн мөлжлөгт өртөх эрсдэл байсаар байна.
3. Ажлын байран дахь бэлгийн дарамтыг судалсан судалгаа байхгүй бөгөөд энэ асуудал далд нуугдмал байдалтай, хууль эрх зүйн хүрээнд авч хэлэлцэгдэхгүй, шийдвэрлэгдэхгүй байсаар байна.

4. Эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүдийн ажиллаж буй салбарууд ялгаатай, цалин хөлс нь зөрүүтэй байна. Ялангуяа хувийн хэвшилд хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүдийн дундаж цалин эрэгтэйчүүдийнхээс доогуур байна.
5. Хүүхэд болон ахмад настнуудыг харах үйлчилгээ дутмаг байдгаас эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх боломж хязгаарлагдаж байна.
6. Эрэгтэйчүүдийн дундаж наслалт эмэгтэйчүүдийнхээс даруй 9,6 жилээр богино байна.
7. Эрэгтэйчүүдийн бэртэл гэмтэл, гэмт хэрэгт холбогдох байдал эмэгтэйчүүдээс хэд дахин илүү өндөр үзүүлэлттэй байна.
8. Хөвгүүдийг хууль бусаар хөдөлмөр эрхлүүлэх ялангуяа морь унуулах, мал маллуулахын тулд сургууль завсардуулах явдал байсаар байна.
9. Эцэг эхчүүд хөвгүүд, охидынхоо боловсролд ялгаатай хандсанаас хөдөө орон нутагт эхнэргүй малчин залуучуудын тоо нэмэгдэх, дотоод шилжилт хөдөлгөөн ихсэх нөхцөл болж байна.
10. Эрэгтэйжсэн улс төрийн бүтэц нь шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд саад болж байна.

НОМ ЗҮЙ

- [1] <http://hdr.undp.org/en/composite/GII>
- [2] <http://www3.weforum.org/docs/WEFGGGR2017.pdf>
- [3] Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол улсын засгийн газрын ээлжит 8, 9-р илтгэл
- [4] Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгааны тайлан, УБ 2017
- [5] Статистикийн мэдээллийн нэгдсэн сан
- [6] Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан, АНУ-ын ЭСЯ, УБ 2017
- [7] Олон улсын хөдөлмөрийн байгууллага 1958
- [8] Монгол улс дахь жендэрийн эрх тэгш байдал: *Нөхцөл байдлын товч үнэлгээ, Баримт бичгийн судалгаа*, УБ 2014
- [9] Монгол Улсын хөдөлмөрийн зах зээл дэх жендэрийн тэгш бус байдлын талаарх чанарын судалгаа, УБ 2018
- [10] Монгол улс: хөдөлмөрийн зах зээл дэх жендэрийн тэгш бус байдал, бодлогын зөвлөмж, УБ 2013
- [11] Засгийн газрын мэдээ 2018.11.14
- [12] Улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо: олон нийтийн санаа бодлын судалгааны тайлан, 2012